



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2017 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/235

Улаанбаатар хот

Төрийн аудитын байгууллагын шагналын
журмыг шинэчлэн батлах тухай


Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зйлийн 13.4.5, 13.4.7 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн аудитын байгууллагын шагналыг журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Төрийн хяналтын тэргүүний ажилтан” цол, тэмдгээр шагнуулахаар өргөн мэдүүлсэн ажилтны анкет, тодорхойлолтын загварыг хоёрдугаар хавсралтаар, “Төрийн хяналтын тэргүүний ажилтан тэмдэг”-ийн үнэмлэхний загварыг гуравдугаар хавсралтаар, “Төрийн аудитын байгууллагын “Хүндэт жуух бичиг”-ийн загварыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2011 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 63 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын төв байгууллагын шагналын журам”-ыг 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэхүү тушаалаар баталсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжүүлж ажиллахыг Тамгын газрын дарга /Ц.Ганболд/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

- 2.3.1. Төрийн албанд 5-аас доошгүй жил, төрийн аудитын байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан байх;
- 2.3. Төрийн аудитын байгууллагын "Хүндэт жуух бичиг"-ээр шагнуулахаар тодорхойлсон ажиглан, албан хаагч нь дор дурьдсан болзол хангасан байна. Үүнд:
 - 2.2. "Төрийн хяналтын тэргүүний ажиглан" цол, тэмдгийг иргэнд зөвхөн нэг удаа олгоно.
 - 2.1.1. Улсад 15-аас доошгүй жил, төрийн хяналт, аудит, дотоод аудитын чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан байх;
 - 2.1.2. Ажил, мэргэжлээрээ хамт олноо манлайлан мэргэжлийн өндөр үр чадвар гарган эрхэлсэн ажилдаа өндөр амжилт үзүүлж, сүүлийн 3 жилд үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээгээр "А", "Б" үнэлэгдсэн байх;
 - 2.1.3. Төрийн аудитын байгууллагын зорилго, чиг үүргийг хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан ба төрийн аудитын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхэд шинэлэг арга ажиллагаа нэвтрүүлсэн байх;
 - 2.1.4. Төрийн аудитын байгууллагын ажиглалтын ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, ашиг сонирхлын болон ёс зүйн аливаа зөрчил гаргагч байх.
- 2.1. "Төрийн хяналтын тэргүүний ажиглан" цол, тэмдгээр шагнуулахаар тодорхойлсон ажиглан, албан хаагч нь дор дурьдсан болзол хангасан байна. Үүнд:

Хоёр. Шагнал олгох болзол

- 1.1. Төрийн хяналтын чиг үүрэг, хуулиар хүлээсэн үүрэг үнэнч, шударгаар биелүүлж, төрийн албанд олон жил тогтвортой, үр бүтээлтэй ажиллаж, эрхэлсэн ажилдаа өндөр амжилт гарган төрийн хяналтын тогтолцоог хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан төрийн албан хаагчид болон ажиглант Төрийн аудитын байгууллагын шагналаар шагнахад энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2. Төрийн аудитын байгууллагын шагнлын зорилго нь төрийн хяналт, аудитын чиглэлээр үр бүтээлтэй ажиллаж байгаа хүмүүсийн амжилт, бүтээлийг үнэлж, алдаршуулах, тэдний ажлын идэвх санаачлагыг хөхиүлэн дэмжиж, урамшуулахад оршино.
- 1.3. Төрийн аудитын байгууллагын шагнал нь дор дурьдсан төрөлтэй байна.
 - 1.3.1. "Төрийн хяналтын тэргүүний ажиглан" цол, тэмдэг;
 - 1.3.2. Төрийн аудитын байгууллагын "Хүндэт жуух бичиг".

Нэг. Нийтлэг үндэслэл

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН
ШАГНАЛЫН ЖУРАМ

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны 8-ны өдрийн дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

10122

- 2.3.2. Ажил, мэргэжлээрээ хамт олноо манлайлан мэргэжлийн өндөр ур чадвар гарган эрхэлсэн ажилдаа өндөр амжилт үзүүлж, сүүлийн 2 жилд үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээгээр "А", "В" үнэлэгдсэн байх;
- 2.3.3. Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, ашиг сонирхлын болон ёс зүйн аливаа зөрчил гаргаагүй байх.

Гурав. Шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох журам

- 3.1. Энэхүү журмын 2.1, 2.2-т заасан болзлыг хангасан гэж үзсэн ажилтан, албан хаагчийн тодорхойлолтыг дараахь байгууллага, албан тушаалтан Монгол Улсын Ерөнхий аудиторт уламжилна. Үүнд:
- 3.1.1. Үндэсний аудитын газрын Тамгын газрын дарга нь газар, хэлтэс албадын удирдлага болон тамгын газрын албан хаагчдын;
- 3.1.2. Үндэсний аудитын газрын төрөлжсөн аудитын газрын дарга, захирал нь тус газрын албан хаагчдын;
- 3.1.3. Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор нь тус газрын албан хаагчдын;
- 3.1.4. Төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтан нь тухайн байгууллагын албан хаагчийн;
- 3.1.5. Төрийн хяналтын чиг үүргийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгжийн удирдлага, тухайн байгууллагын ажилтны.
- 3.2. Ажилтан, албан хаагчийг уг шагналд тодорхойлохдоо хамт олныхоо хурлаараа хэлэлцүүлэн нэр дэвшүүлж, шийдвэрийг зохих журмын дагуу албажуулж, холбогдох баримт бичгийн хамт ирүүлнэ.
- 3.3. Шагналд тодорхойлсон ажилтны талаарх баримт бичиг, саналыг Тамгын газар судлан үзэж дүгнэлт гарган Монгол Улсын Ерөнхий аудиторт танилцуулан шийдвэрлүүлнэ. Монгол Улсын Ерөнхий аудитор "Шагнах тухай" тушаал гаргана.
- 3.4. "Төрийн хяналтын тэргүүний ажилтан" цол, тэмдэг, "Хүндэт жуух бичиг"-ийг улсын тэмдэглэлт ой, зайлшгүй шагнах шаардлагатай үед тухай бүр Монгол Улсын Ерөнхий аудитор танилцан шийдвэрлэнэ.
- 3.5. Шагналыг энэхүү журамд заасан санал, тодорхойлолт гаргасан эрх бүхий байгууллага, албан тушаалтан ёслол хүндэтгэлтэйгээр гардуулна.
- 3.6. Шагнуулахаар ирүүлсэн баримт бичгийг буцааж олгохгүй ба Үндэсний аудитын газрын архивт хадгалагдан үлдэнэ.

Дөрөв. Шагналын баталгаа, дагалдах мөнгөн шагнал

- 4.1. "Төрийн хяналтын тэргүүний ажилтан" цол, тэмдгийн үнэмлэх, "Хүндэт жуух бичиг"-т Монгол Улсын Ерөнхий аудитор гарын үсэг зурах бөгөөд тамга дарж баталгаажуулсан байна.
- 4.2. "Төрийн хяналтын тэргүүний ажилтан" цол, тэмдгээр шагнагдсан ажилтанд тухайн ажиллаж байгаа байгууллага нь 100.000 /нэг зуун мянган/ төгрөгийн, Хүндэт жуух бичиг"-ээр шагнагдсан ажилтанд 30000 /гучин мянган/ төгрөгийн дагалдах мөнгөн шагналыг тус тус олгоно.

Тав. Шагнуулах ажилтан, албан хаагчдын баримт бичгийн бүрдүүлэлт


- 5.1. Шагналд өргөн мэдүүлсэн хүний анкет;
- 5.2. Ажил байдлын тодорхойлолт;
- 5.3. Тухайн байгууллагын хамт олны хурлаар хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэл;
- 5.4. Тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсэг бүхий албан тоот.

Зурга. Бусад

- 6.1. Онцгой үүрэг гүйцэтгэж гавьяа байгуулсан ажилтныг энэхүү журамд заасан болзлыг харгалзахгүйгээр Төрийн албаны тухай хуульд заасан зохицуулалтын хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын санаачлагаар "Төрийн хяналтын тэргүүний ажилтан" цол, тэмдгээр шагнаж болно.
- 6.2. Төрийн хяналтын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан ажилтныг шагнуулах саналыг ажиллаж байсан байгууллага Монгол Улсын Ерөнхий аудиторт гаргаж болно.
- 6.3. Энэхүү журамд заасан болзол болон баримт бичгийн шаардлага хангаагүй материалыг Тамгын газар буцаана.

---000---

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2017 оны 2 дугаар сарын 18 -ны өдрийн
А/235 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**"ТӨРИЙН ХЯНАЛТЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН" ЦОЛ,
ТЭМДЭГ-ЭЭР ШАГНУУЛАХ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН АЖИЛТНЫ
АНКЕТ, ТОДОРХОЙЛОЛТ**

2017 оны ___-р сарын ___-ний өдөр

1. Овог, нэр:
2. Ургийн овог:
3. Хүйс:
4. Төрсөн он:
5. Регистрын дуагаар:
6. Төрсөн газар:
7. Үндсэн захиргаа:
8. Албан тушаалын анилал, зэрэглэл, зэрэг дэв:
9. Боловсролын талаар (ерөнхий, тусгай, дунд, дээд боловсрол, бакалаврын болон магистрын зэргийг оролцуулна)-х мэдээлэл:

Сургуулийн нэр	Орсон он, сар	Төгссөн он, сар	Эзэмшсэн мэргэжил, дипломын дугаар	боловсрол, гэрчилгээ,

10. Туршлагын талаарх мэдээлэл:
 - Төрийн албанд:
 - Төрийн хяналтын албан тушаалд:
11. Хөдөлмөр эрхлэлтийн байдал:

Ажилласан байгууллага, газар, хэлтэс	Албан тушаал	Ажилд орсон он сар	Ажлаас гарсан он, сар


12. Төр, засгийн ямар шагналаар хэзээ шагнагдсан:

Шагналын нэр	Зарлиг, захирамж, тушаалын нэр, он, сар, өдөр, дугаар	Үнэмлэхний дугаар	Шагнал олгосон үндэслэл, тайлбар

13. Шагнагдах үндэслэл:
14. Байгууллага, хамт олны саналын хувь:

БАЙГУУЛЛАГЫН ДАРГЫН ГАРЫН ҮСЭГ


Үнэмлэхний хавтас нь хүрэн улаан өнгөтэй байна



Б. Гадна тал

<p>2017 оны _____ сарын _____-ны өдөр</p> <p>Дугаар _____</p> <p>ТЭМДЭГ</p>	<p>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР Д.ХҮРЭЛБААТАР</p> <p>Монголд Улсад төрийн хяналтын иргт үүргийг хэрэгжүүлэхэд олон жил үр бүтээлтэй ажиллаж, эрхэлсэн ажиллаа өндөр амжилт гаргасныг тань өндөрөөр үнэлж, "Төрийн хяналтын тэргүүний ажилтан" цол, тэмдгээр шагнав.</p> <p>Хүндэт _____ танаа</p>
---	---


А. Дотор тал




ТӨРИЙН ХЯНАЛТЫН ТЭРҮҮНИЙ АЖИЛТАН ТЭМДЭГ-НИЙ ҮНЭМЛЭХНИЙ ЗАГВАР

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны 18-ны өдрийн А/235 дугаар тушаалын гурвдугаар хавсралт

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн
19/235 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮНДЭТ ЖУУХ БИЧГИЙН ЗАГВАР

<p>Дотор талд</p>  <p>ХҮНДЭТ ЖУУХ БИЧИГ</p> <p>201 ____ оны ____ -р сарын ____ -ны өдөр</p>	<p>Хүндэт _____ танаа</p> <p>Монголд Улсад төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд олон жил үр бүтээлтэй ажиллаж, эрхэлсэн ажилдаа өндөр амжилт гаргасныг тань өндрөөр үнэлж, Төрийн аудитын байгууллагын “ХҮНДЭТ ЖУУХ БИЧИГ” -ээр шагнав.</p> <p>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР Д.ХҮРЭЛБААТАР</p>
---	--

Нүүр



**ХҮНДЭТ ЖУУХ
БИЧИГ**

